



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫН
2016-2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**



2018 он

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор (Л.Ламаачин)</p> <p>Аудитын менежер (Д.Гансүх)</p> <p>Ахлах аудитор (Б.Чимэдцэрэн)</p> <p>Аудитор (П.Норпил)</p> <p>2018 оны 10 дугаар сар</p> <p>Уг тайланг www.audit.mn, https://www.facebook.com/uvurkhangai.audit facebook хаягаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас,70323253 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ:</p> <p>(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 405 тоот)</p>	<p>Товчилсон үгийн тайлбар</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Бүлэг 1</p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг нормативаас хэтрүүлж, зарим шаардлага хангахгүй цэгт олгосон байна.</p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг норматив мөрдөхгүйгээр олгож, харин тамхины зөвшөөрлийг хуульд заасан байршлын дагуу олгосон байна.</p> <ul style="list-style-type: none">✓ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг норматив мөрдөхгүйгээр олгож байна.✓ Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг аудитад хамрагдсан сумдаас Бат-Өлзий сумаас бусад нь хуулийн дагуу олгож байна. <p>Шаардлага хангаагүй иргэд, аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон байна.</p> <ul style="list-style-type: none">✓ Тусгай зөвшөөрөл хүсэгч зарим иргэд, ААН баримт материалаа хууль журмын дагуу бүрдүүлээгүй байна.✓ Зарим иргэд, ААН мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл, дүгнэлт гаргуулаагүй байхад орон тооны бус зөвлөл дэмжсэн байна. <p>Бүлэг 2</p> <p>Орон нутгаас олгогдож буй тусгай зөвшөөрөл, улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төвлөрүүлэлтэд тавих хяналт хангалтгүй байна.</p> <p>Нөхцөл шаардлага биелүүлээгүй цэгт тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол байна.</p> <ul style="list-style-type: none">✓ Аймаг, сумын Засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн газарт үйл ажиллагаа явуулж байна.✓ Орон тооны бус ажлын хэсэг болон салбар зөвлөл тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд журмын дагуу хяналт тавиагүй байна. <p>Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг хууль, журмын дагуу тогтоосон ч хураамжийн орлогыг хугацаанд нь төсөвт гүйцэд төвлөрүүлээгүй, түүнд тавих хяналт хангалтгүй байна.</p>
--	---

	<ul style="list-style-type: none"> ✓ Аймаг, сумын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход тогтоох тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуулийн дагуу тогтоож байна. ✓ Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг хугацаанд нь төсөвт гүйцэд төвлөрүүлээгүй байна. ✓ Нотариатын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтэд тавьж буй хяналт хангалтгүй байна. <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал</p> <p>Саналд өгсөн тайлбар</p> <p>Хавсралтууд</p>
--	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ӨВА	Өвөрхангай аймаг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ААН	Аж ахуйн нэгж
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж

Ерөнхий зүйл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан ӨВА-2018-01-ГА төлөвлөгөөг үндэслэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим заалтын 2016-2017 оны хэрэгжилт, үр дүнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим заалтын 2016-2017 оны хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд:

- Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрлийг хууль журмын дагуу олгож, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж байгаа эсэх. /согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд болон тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж, нотариатын үйлчилгээний хураамжийн хэрэгжилт/
- Орон нутгаас олгогдсон тусгай зөвшөөрөлд тавих хяналт, улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төвлөрүүлэлт үр дүнтэй байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Бат-Өлзий, Баянгол, Богд, Гучин-Ус, Нарийнтээл, Төгрөг, Уянга, Хужирт, Хархорин зэрэг сумд, аймгийн Татварын хэлтэс, МХГ, ЗДТГ-ын СТСХ, ХЭЗХ зэрэг байгууллагыг хамруулан тэдгээрийн эрх зүйн үндэслэл, гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, хэрэгжилтийн талаарх тайлан, судалгаа, мэдээлэлд үндэслэн бодит байдлыг газар дээр нь үзэж, холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ: Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтнүүд, аймаг, сумдын удирдлага болон бусад ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль, эрх зүйн байдлыг бодит байдалтай харьцуулах, мэдээ, судалгаа, ажлын тайланд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг баримталсан бөгөөд аудитын хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулах ажиллагаа хийгдэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Татварын ерөнхий хууль
- ✓ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- ✓ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- ✓ Тамхины хяналтын тухай хууль

- ✓ УИХ-ын 2003 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр"
- ✓ Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан "Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам"
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд
- ✓ Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын Захирамж, бусад эрхийн актууд

Аудитын стандартын талаарх мэдээгдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ: Үндэсний аудитын газрын харьяа Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан ӨВА-2018-01-ГА аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав. Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор Б.Чимэдцэрэн, аудитор П.Норпил нар 2018 оны 9 дүгээр сарын 10-аас 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудитаар 4,331.7 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 4,531.7 мянган төгрөгийн үр өгөөж тооцов.

АУДИТЫН ДҮН

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫН 2016-2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг нормативаас хэтрүүлсэн бөгөөд зарим шаардлага хангахгүй цэгт олгосон байна.

1.1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг норматив мөрдөхгүйгээр олгож, харин тамхины зөвшөөрлийг хуульд заасан байршлын дагуу олгосон байна.

1.1.1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг норматив мөрдөхгүйгээр олгож байна.

Үйлдвэр, худалдааны сайдын “Норматив тогтоох тухай” 2008 оны 05 дугаар тушаалд “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог нийслэл, аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй байх, сумын төвд согтууруулах ундаа худалдах цэг 1, үйлчлэх цэг 1 байх”-аар заажээ. МХЕГ-аас 2016 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр аймгийн Засаг даргад ирүүлсэн 1/2407 тоот албан бичигт “... Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалын дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй, сумын төвд 1000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй байхаар зохион байгуулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт, шалгалт, тандалт судалгааг хийж, зөрчил гаргаж байгаа тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээг авч ажиллах...” гэсэн байна. Тус аймагт энэ нормативыг мөрдөөгүй бөгөөд МХЕГ-ын албан бичиг ирснээс хойш зөвхөн 2016 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох захирамж дараах байдлаар гарчээ. Үүнд:

- 09 дүгээр сарын 16-ны өдрийн а/423 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийг сунгах 26, шинээр олгох 10, хүчингүй болгох 1

- 11 дүгээр сарын 22-ны өдрийн а/522 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийг сунгах 13, шинээр олгох 5,
- 12 дугаар сарын 16-ны өдрийн а/566 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийг сунгах 113, шинээр олгох 16, хүчингүй болгох 3
- 12 дугаар сарын 27-ны өдрийн а/590 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийг сунгах 108, шинээр олгох 9 байна.

Статистикийн хэлтсийн мэдээллээс харахад 2017 оны эцсийн байдлаар тус аймагт 115,684 хүн оршин сууж байна. Үйлдвэр худалдааны сайдын тогтоосон нормативаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог тооцож үзвэл нийтдээ 57-58 цэг байхаар байтал одоогийн байдлаар 485 байгаа нь дунджаар 238 хүнд нэг цэг ногдож байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Д//д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо			Хүн амын тоо /2017он/	Нэг цэгт ногдох хүний тоо
		худалдаа	үйлчилгээ	нийт		
1	Баян-Өндөр	10		10	3,816	381.6
2	Бүрд	5		5	2,951	590.2
3	Бат-Өлзий	43	4	47	7,499	159.6
4	Баруунбаян-Улаан	8		8	2,803	350.4
5	Баянгол	5	1	6	3,939	656.5
6	Гучин-Ус	10		10	2,195	219.5
7	Өлзийт	4		4	2,446	611.5
8	Есөнзүйл	8		8	3,115	389.4
9	Зүүнбаян-Улаан	3		3	4,066	1355.3
10	Богд	19	1	20	5,626	281.3
11	Нарийнтээл	13	2	15	3,663	244.2
12	Сант	12		12	3,644	303.7
13	Тарагт	5		5	3,373	674.6
14	Төгрөг	8		8	2,764	345.5
15	Уянга	29	2	31	9,512	306.8
16	Хайрхандулаан	7		7	3,518	502.6
17	Хужирт	28	4	32	6,751	211.0
18	Хархорин	37	18	55	12,516	277.6
19	Арвайхээр	158	41	199	31,487	158.2
НИЙТ ДҮН		412	73	485	115,684	238.5

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог нормативд заасан хэмжээтэй нь харьцуулж үзэхэд 11 сум 1-9 цэгээр, 5 сум 10-29 цэгээр, 3 сум 43-183 цэгээр тус, тус илүү байна.

1.1.2. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг аудитад хамрагдсан сумдаас Бат-Өлзий сумаас бусад нь хуулийн дагуу олгосон байна.

Ихэнх сумын худалдааны цэгүүд төвдөө байрладаг учраас ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс ойр зайд байдаг тул тамхины тусгай зөвшөөрлийг гэр хорооллын алслагдсан маш цөөхөн дэлгүүрт олгосон байна. Арвайхээр сум зураглал гарган тамхи худалдан борлуулахыг хориглох бүсээс алслагдсан 28 дэлгүүрт тусгай зөвшөөрөл олгожээ. Аудитад хамрагдсан сумдаас зөвхөн Бат-Өлзий сум Тамхины хяналтын тухай хуулийг зөрчин¹ байршил харгалзахгүйгээр 30 дэлгүүрт тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон байна.

1.2. Шаардлага хангаагүй иргэд, аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон байна.

1.2.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч зарим иргэд, ААН баримт материалаа хууль журмын дагуу бүрдүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 72 дугаар тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журмын дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байх ёстой. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /хуулийн этгээд бол байгууллагын тамга тэмдэг бүхий албан бичиг/
- Тусгай зөвшөөрөл хүсэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар /хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар/
- Худалдаа үйлчилгээний цэгийн гадна, дотно талын дүрст зураг
- Тохирлын гэрчилгээний хуулбар
- Тусгай зөвшөөрлийг сунгах бол оршин байгаа газрын багийн Засаг дарга болон цагдаагийн байгууллагын захиргааны зөрчлийн талаарх тодорхойлолт зэргийг ирүүлсэн байна.

Аудитын явцад тусгай зөвшөөрөл хүсэгчдийн баримт материалын бүрдүүлэлтийг хэсэгчлэн үзэхэд дараах зөрчил байна. Тухайлбал:

1. Баян-Өндөр сум. **Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй:** С.Отгонбаярын Есөн-Уулзвар дэлгүүр,
2. Бүрд сум. **Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй:** Ч.Мөнхөөгийн Эрээн-Уул дэлгүүр, Д.Оргодолын Их бүрд дэлгүүр, Д.Цэрэндэжидийн Тэнгэрийн оргилго дэлгүүр, **Худалдаа үйлчилгээний цэгийн гадна, дотно талын дүрст зураггүй:** Д.Оргодолын Их бүрд дэлгүүр

¹ 6.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараах зүйлийг хориглоно: 6.7.14.ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;

3. Өлзийт сум. **Худалдаа үйлчилгээний цэгийн гадна, дотно талын дүрст зураггүй:** Д.Должинсүрэнгийн Их цагаан хөтөл дэлгүүр, Өлзийт баян түмэн ХХК-ийн Өлзийт баян түмэн дэлгүүр

4. Есөнзүйл сум. **Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /хуулийн этгээд бол байгууллагын тамга тэмдэг бүхий албан бичиг/-гүй:** Алтан жолоо хүлэг ХХК-ийн Алтан жолоо хүлэг дэлгүүр, **Тохирлын гэрчилгээний хуулбаргүй:** Ц.Мөнхбатын Мөнх үржих дэлгүүр,

5. Зүүнбаян-Улаан сум. **Тусгай зөвшөөрөл хүсэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар байхгүй:** П.Гэрэлсүрэнгийн Тахилгат дэлгүүр, **Худалдаа үйлчилгээний цэгийн гадна, дотно талын дүрст зураггүй:** Ү.Цэнд-Очирын Бат-Арвижих дэлгүүр, П.Гэрэлсүрэнгийн Тахилгат дэлгүүр, Өгөөмж-Арцат ХХК-ийн Өгөөмж дэлгүүр, **Тохирлын гэрчилгээний хуулбар байхгүй:** Ү.Цэнд-Очирын Бат-Арвижих дэлгүүр,

6. Нарийнтээл сум. **Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /хуулийн этгээд бол байгууллагын тамга тэмдэг бүхий албан бичиг/-гүй:** Шаргын ундраа ХХК-ийн Шаргын ундраа хүнсний дэлгүүр,

7. Хужирт сум. **Тусгай зөвшөөрөл хүсэгчийн иргэний үнэмлэхийн хуулбаргүй:** О.Дорждэрэмийн Ханги хайрхан дэлгүүр, **Тохирлын гэрчилгээний хуулбаргүй:** С.Даваасүрэнгийн Төв дэлгүүр

8. Арвайхээр сум. **Тусгай зөвшөөрөл хүсэгчийн иргэний үнэмлэхийн хуулбаргүй:** Н.Батбаяр Баян дагналтай дэлгүүр, Г.Батцэцэгийн Diamond баар, А.Бямбын Сангийн далай дэлгүүр, **Худалдаа үйлчилгээний цэгийн гадна, дотно талын дүрст зураггүй:** Н.Батбаяр Баян дагналтай дэлгүүр, Г.Батцэцэгийн Diamond баар, П.Туяагийн Хүлэг дэлгүүр, А.Сүхбаатарын Сакура дэлгүүр, О.Гантулгын Идэр шагай дэлгүүр, Д.Батбаяр Баянзүрх дэлгүүр, Ч.Бадам Дэлгэрэх дэлгүүр, Ц.Цэдэндорж Арцат ХХК худалдааны төв, Л.Мягмар Эрдэнэсан дэлгүүр, А.Гарамсэд Хунт дэлгүүр, Г.Алтангэрэл Хангарьд дэлгүүр, **Тохирлын гэрчилгээний хуулбар байхгүй:** Ц.Сангидоржийн Баян бургатай дэлгүүр, Ж.Жанцандоржийн Хараа баар, Ц.Дагвадоржийн Их булаг, Ц.Чимэддоржийн Түмэн эх дэлгүүр, Д.Оюунгэрэл Өлзийт баар, Б.Даваасүрэн Баянцагаан дэлгүүр байна.

1.2.2. Зарим иргэд, ААН мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл, дүгнэлт гаргуулаагүй байхад орон тооны бус зөвлөл дэмжсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 72 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу шаардлага хангасан эсэх талаар цагдаагийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй болон цагдаагийн байгууллагын дүгнэлтээр шаардлага хангаагүй байхад орон тооны бус зөвлөл дэмжсэн дүгнэлт гаргасан байна. Үүнд:

1. Бат-Өлзий сум. **Цагдаагийн байгууллагын дүгнэлтээр шаардлага хангаагүй:** Д.Баясгалангийн Хуст ундарга дэлгүүр, Ц.Ганболд Зэндмэнэ дэлгүүр

2. Баруунбаян-Улаан сум. **Цагдаагийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй:** А.Баатарсүхийн Баян богд дэлгүүр, Ч.Төрбатын Жаргалант дэлгүүр, Ж.Батбаатарын Баян дөхөм дэлгүүр, П.Чулуунбаатарын Цагаан нуур дэлгүүр, В.Бямбасүрэнгийн Энх өгөөж дэлгүүр

3. Баянгол сум. **Цагдаагийн байгууллагын дүгнэлтээр шаардлага хангаагүй:** Ц.Төмөртогтохын Ота дэлгүүр, Тэмүүлэн булаг ХХК-ийн Тэмүүлэн булаг дэлгүүр

4. Гучин-Ус сум. **Цагдаагийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй:** Ё.Үйтүмэнгийн Дэвжих дэлгүүр, Д.Одончимэгийн Дүнчүүр дэлгүүр

5. Уянга сум. **Цагдаагийн байгууллагын дүгнэлтээр шаардлага хангаагүй:** Т.Шийлэгцэрэн Яруу кафе

6. Хархорин сум. **Цагдаагийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй:** Гучингийн хөсөг ХХК-ийн Дэлгэрэх дэлгүүр, Ё.Гомбохорлоогийн Өлзий дэлгүүр

1.3 Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлага байна.

1.3.1 Нотариатын үйлчилгээний хураамжийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Аудитад хамрагдсан ихэнх сумд улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг иргэний бүртгэлийн, нотариатын, газрын гэх мэтээр нэр төрлөөр нь бус нийт дүнгээр өмнөх жилийн гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөж байна.

1.3.2 Тусгай зөвшөөрөл сунгах цэгийн тоог үндэслэн улсын тэмдэгтийн хураамжийг төлөвлөжээ.

Улсын тэмдэгтийн хураамжийг 2016 онд 314.4 сая төгрөгөөр төлөвлөж, орлогын төлөвлөгөө 29.3 хувиар буюу 92.1 сая төгрөгөөр тасарсан, 2017 онд 223.1 сая төгрөгөөр төлөвлөж, орлого 12.9 хувиар буюу 28.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөө 2016 онд тасарсан, 2017 онд давж биелсэн шалтгаан нь 2016 оны сүүлчээр олгосон тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 2017 оны эхэнд орсонтой холбоотой байна.

2. Орон нутгаас олгогдож буй тусгай зөвшөөрөл, улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төвлөрүүлэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

2.1 Нөхцөл шаардлага биелүүлээгүй цэгт тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол гарсан байна.

2.1.1. Аймаг, сумын Засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн газарт үйл ажиллагаа явуулж байна.

Аудитад хамрагдсан сумд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг сумын Засаг даргын захирамжаар олгож байна. Тусгай зөвшөөрөл авсан иргэд, ААН-үүд хууль, журмын дагуу зөвшөөрөгдсөн газарт үйл ажиллагаа явуулж байна.

2.1.2. Орон тооны бус ажлын хэсэг болон салбар зөвлөл тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд журмын дагуу хяналт тавиагүй байна.

Журамд заасны дагуу сумдын ИТХ-аас согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход санал дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус ажлын хэсгийг томилж, ажиллах журмыг баталсан байна. Орон тооны бус ажлын хэсэг нь санал асуулгын дүн, хууль тогтоомжийн хэрэгжилт, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, цагдаагийн газрын шаардлага хангасан эсэх талаар дүгнэлт гаргаж, сумын ИТХ-аар хэлэлцүүлж байгаа боловч зарим тохиолдолд цагдаагийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй байхад ажлын хэсгийн дүгнэлт гаргасан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус салбар зөвлөл нь тусгай зөвшөөрөл хүссэн иргэн, ААН-ийн өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч, хуралдаанаар хэлэлцэж, нөхцөл шаардлагыг хангасан гэж үзвэл тусгай зөвшөөрөл олгохыг дэмжих, хангаагүй бол олгохоос татгалзах чиг үүрэгтэй.

Гэтэл согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийн дүгнэлтгүйгээр дараах цэгүүдэд аймгийн Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрөл олгожээ. Үүнд:

1. Гучин-Ус сум: Б.Балжиннямын Их богд, Л.Ганбатын Цавчир, Ц.Отгонбаярын Аргалант, Ё.Үйтүмэнгийн Дэвжих, Т.Чулуунхүүгийн Ачлал, Д.Одончимэгийн Дүнчүүр, Б.Батбаатарын Баялаг дэлгүүрүүд,

2. Зүүнбаян-Улаан сум: Ү.Цэнд-очирын Бат-Арвижих, О.Хандаагийн Баянцацрал хайрхан, П.Гэрэлсүрэнгийн Тахилгат, Б.Амгаланбаяр Өгөөмж-Арцат ХХК-ийн Өгөөмж дэлгүүрүүд,

3. Сант сум: Д.Сампилноровын Өсөх-Арвай дэлгүүр,

4. Уянга сум: Ц.Жаргалсайханы Түмэн тулга, Б.Лхагвадолгорын Өргөжих, Т.Пүрэвсүрэнгийн Арвин дэлгэрэх, Ч.Ганбаатарын Тээл, Ц.Тогтохын Оргил, Д.Дагвадоржийн Дээж, Б.Цэндсүрэнгийн Түшээ, Д.Ганхуягийн Итгэл, Ө.Төмөрхуягийн Мөнх-Ундрал, Ч.Батнасангийн Босго нуур, С.Цэрэнбатын Жаргалант, Д.Орхоны Уянга дэлгүүрүүд, Ц.Жаргалсайханы Түмэн-Эрдэнэ караоке паб,

5. Арвайхээр сум: М.Батцэцэгийн Их зараа, Н.Оюунчимэгийн Оюу төв, Т.Балжиннямын Нарт дэлгэрэх дэлгүүрүүд байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 72 дугаар тогтоолын 6.2-т “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэг нь стандарт шаардлага хангаагүй, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, ажлын хэсгийн дүгнэлтээр татгалзсан хариу ирүүлсэн, аймгийн орон тооны бус зөвлөлөөс тогтоосон босго оноонд хүрээгүй бол аймгийн Засаг даргаас тусгай зөвшөөрлийг олгохгүй” гэснийг зөрчин ажлын хэсгийн дүгнэлтээр Богд сумын иргэн Х.Амарсанаагийн Баянбулаг хүнсний дэлгүүрт 75 хувь нь татгалзсан, Тэгш дөрвөн хүсэл ХХК-ийн Баянчулуу хүнсний дэлгүүрт 100 хувь татгалзсан саналтай байхад тусгай зөвшөөрлийг сунгахаар аймгийн Засаг даргын захирамж гарсан байна.

2.2 Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг хууль, журмын дагуу тогтоосон ч хураамжийг хугацаанд нь төсөвт гүйцэд төвлөрүүлээгүй байна.

2.2.1.Аймаг, сумын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход тогтоох тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуулийн дагуу тогтоож байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3² дахь хэсэгт заасны дагуу аймгийн ИТХ 2011 оны 07 дугаар сарын 19-ний өдөр “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 10/04 тоот тогтоол гаргасан байна. Энэ тогтоолоор Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгоход 100.0 мянган төгрөг, Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 600.0 мянган төгрөг, бусад суманд 300.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 200.0 мянган төгрөг, бусад суманд 100.0 мянган төгрөг, Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 120.0 мянган төгрөг, бусад суманд 60.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 45.0 мянган төгрөг, бусад суманд 24.0 мянган төгрөг, Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 800.0 мянган төгрөг, бусад суманд 500.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 400.0 мянган төгрөг, бусад суманд 200.0 мянган төгрөг, Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 240.0 мянган төгрөг, бусад суманд 150.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 120.0 мянган төгрөг, бусад суманд 75.0 мянган төгрөг байхаар заажээ.

² 6.3.Энэ хуулийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

2.2.2. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг хугацаанд нь төсөвт гүйцэд төвлөрүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг, сумдын Засаг даргын захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгож, аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2016-2017 онд олгосон тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 83,120.0 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг дараах цэгүүд тэмдэгтийн хураамжийг хугацаанд нь төлөөгүй байгаа нь дээрх журмын 9.1³ дэх хэсгийг зөрчсөн байна. Үүнд:

- С.Отгонсүрэнгийн Буян-Арвижих баар 1 жилийн дараа,
- Д.Мягмарчулууны Номин хүнсний дэлгүүр 9 сарын дараа,
- Хуримын ордоны баар 9 сарын дараа,
- Б.Цогтбаярын Дэлгэрэх хүнсний дэлгүүр 10 сарын дараа төлсөн байна.
- Бат-Өлзий сумын Д.Баасанцэрэнгийн Ундрах дэлгүүр 200.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж дутуу төлсөн байсныг аудитын явцад төсөвт оруулсан болно.
- 2016 оны 9 дүгээр сард тусгай зөвшөөрөл шинээр авсан Д.Найманжингийн Өнөр хүнсний дэлгүүр, Өнөр кафе улсын тэмдэгтийн хураамж нийт 900.0 мянган төгрөг төлөөгүй байсанд төлбөрийн акт бичигдлээ.

Аймгийн Засаг даргын 2016 оны а/566, а/590, 2017 оны а/61, а/514 дүгээр захирамжаар согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл гарсан Арвайхээр сумын З.Нэмэхбаярын Баян шарга, М.Батзоригийн Бээмбий, Т.Энхтуяагийн Хишиг-Арвин хүнсний дэлгүүрүүд, Ц.Баяндүүрэнгийн Royal, Т.Цэдэнсодномын Арвай, Р.Оюунхүүгийн Онги үйлчилгээний газрууд, Тарагт сумын Л.Өлзийхишигтийн Арвайн тал хүнсний дэлгүүр үйл ажиллагаа зогссон гэх шалтгаанаар улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй, гэрчилгээгээ аваагүй байна.

Эрх бүхий нотариатч ажилладаг Арвайхээр, Хархорин сумдаас бусад аудитад хамрагдсан сумдаас 2016-2017 онд нотариатын үйлчилгээний хураамж нийт 14,659.8 мянган төгрөг ногдуулж, орон нутгийн төсөвт тайлант онуудад 10,598.3 мянган төгрөгийг, он дамжуулж 629.8 мянган төгрөг төсөвт төвлөрүүлж, 3,431.7 мянган төгрөгийг тайлан мэдээнд тусгаагүй, төсөвт оруулаагүй байсанд төлбөрийн акт бичигдлээ.

2.2.3. Нотариатын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтэд тавьж буй хяналт хангалтгүй байна.

Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогын биелэлтэд тавих хяналт өмнөх аудитаас харьцангуй сайжирсан ч нотариатын хураамжийн орлогын хураамжид тавих хяналт хангалтгүй байна.

Энэхүү хуулийн биелэлтэд татварын алба хяналт тавихаар заасан боловч, аудитад хамрагдсан сум, байгууллагуудаас Төгрөг, Хужирт сумаас бусад сумдын татварын байцаагч нар төдийлөн хяналт тавьдаггүйгээс дараах зөрчил, дутагдал гарч байна. Тухайлбал:

- Улсын тэмдэгтийн хураамжийн тооцоог бүртгэлтэй нь тулгаж хянадаггүй,
- Нэр төрлөөр нь салгаж дүн мэдээ гаргадаггүй,
- УТХ-ийн тооцоог цаг тухайд нь бодож, төсөвт оруулах талаар санаачилгатай ажиллаагүйн улмаас он дамждаг, дутуу ордог, бэлэн мөнгө ажил хариуцаж буй

³ 9.1. Энэхүү журам стандартын ерөнхий шаардлагыг хангасан иргэн, аж ахуйн нэгжид олгох тусгай зөвшөөрлийг Монгол улсын Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу хураамжаа төлсөн тохиолдолд олгоно.

албан тушаалтны гар дээр удаан хугацаагаар байдаг⁴ зэрэг нь сумдын татварын улсын байцаагч нарын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж⁵, харьяалах татварын албанд өгөхөөр хуульд заасан боловч Төгрөг, Хужирт сумаас бусад суманд хариуцсан ажилтнууд тайлан мэдээг гаргаагүй, ихэнх сумдын татварын байцаагч, төрийн сангийн төлөөлөгч нар орлогын нэр төрлөөр салгаж гаргадаггүй орсон хураамжийн нийт дүнгээр тайлагнаж байна.

Зарим сумдын нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нар Нотариатын тухай хуулийн⁶ дагуу нотариатын бүртгэлийг хөтлөөгүй, хураамж төлсөн тухай тасалбар бичээгүй, хураамжийн дүн гаргацгүй, засвартай, зээлийн гэрээг баталгаажуулахдаа хуулийн дагуу хураамж тооцоогүй, нотариатын бүртгэлийн дэвтэрт үйлчлүүлэгч нараар гарын үсэг зуруулаагүй, бүртгэлийн дугаарлалт алдагдсан зэрэг зөрчлүүд байна.

Уянга сумын ЗДТГ-ын дарга нотариатын бүртгэл хийхгүй зөвхөн тамга дарж, гарын үсэг зурж байна. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод нотариатын үйлчилгээний ажлыг хариуцуулахаар тусгаж, тухайн мэргэжилтэн энэ үйлчилгээг иргэдэд үзүүлж, сар бүр тайлан гаргаж, хураамжийг тухай бүрд нь тушааж иржээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, дүнд үндэслэн дараах дүгнэлт өгч байна. Үүнд:

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫН 2016-2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг нормативаас хэтрүүлж, зарим шаардлага хангахгүй цэгт олгосон байна.

1.1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг норматив мөрдөхгүйгээр олгож, харин тамхины зөвшөөрлийг хуульд заасан байршлын дагуу олгосон байна.

- ✓ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг норматив мөрдөхгүйгээр олгож байна.

⁴ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10 000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна.

⁵ 43.1.Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд гаргаж өгнө.

⁶ **26 дугаар зүйл.Нотариатын бүртгэл** 26.1.Нотариатч баримт бичиг, үйл явдлыг гэрчлэхдээ нотариатын бүртгэл хөтөлж түүнд нотариатчийн хийсэн нотариатын үйлдлийг он, сар өдрийн дарааллаар нь үнэн зөв, засваргүй, гаргацтай, тодорхой бичнэ. 26.2.Нотариатын бүртгэлийн дэвтэрт үйлчлүүлэгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хэрэв нотариатын үйлдэл хийхэд тэмдэглэл хөтөлсөн бол энэ тухай тус тус тэмдэглэнэ.26.3.Үйлчлүүлэгч, нотариатын үйлдэл хийхэд оролцсон гэрч, бусад оролцогч нотариатын бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурна.26.4. Нотариатын үйлдэл хийсэн баримт бичигт дарсан баталгааны тэмдгийн дардас дээрх дугаар нь тухайн бүртгэлийн дугаартай ижил байна.26.5.Нотариатын бүртгэлийг уусдаггүй нэг өнгийн бэхээр хөтөлнө.

- ✓ Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг аудитад хамрагдсан сумдаас Бат-Өлзий сумаас бусад нь хуулийн дагуу олгож байна.

1.2. Шаардлага хангаагүй иргэд, аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон байна.

- ✓ Тусгай зөвшөөрөл хүсэгч зарим иргэд, ААН баримт материалаа хууль журмын дагуу бүрдүүлээгүй байна.
- ✓ Зарим иргэд, ААН мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл, дүгнэлт гаргуулаагүй байхад орон тооны бус зөвлөл дэмжсэн байна.

1.3 Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлага байна.

- ✓ Нотариатын үйлчилгээний хураамжийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.
- ✓ Тусгай зөвшөөрөл сунгах цэгийн тоог үндэслэн улсын тэмдэгтийн хураамжийг төлөвлөжээ.

2. Орон нутгаас олгогдож буй тусгай зөвшөөрөл, улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төвлөрүүлэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

2.1 Нөхцөл шаардлага биелүүлээгүй цэгт тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол байна.

- ✓ Аймаг, сумын Засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн газарт үйл ажиллагаа явуулж байна.
- ✓ Орон тооны бус ажлын хэсэг болон салбар зөвлөл тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд журмын дагуу хяналт тавиагүй байна.

2.2 Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг хууль, журмын дагуу тогтоосон, харин хураамжийн орлогыг хугацаанд нь төсөвт гүйцэд төвлөрүүлээгүй, түүнд тавих хяналт хангалтгүй байна.

- ✓ Аймаг, сумын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход тогтоох тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуулийн дагуу тогтоож байна.
- ✓ Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг хугацаанд нь төсөвт гүйцэд төвлөрүүлээгүй байна.
- ✓ Нотариатын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтэд тавьж буй хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Г.Ганболд, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А.Отгонцэцэг, мэргэжилтэн Б.Анхбилэг нарт:

1. Сogтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо сумын салбар зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтүүдийг аймгийн зөвлөлийн хэлэлцсэн санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргаж байх.

2. Журамд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй, зөрчсөн цэгүүдэд тусгай зөвшөөрөл олгохгүй, түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авч байх

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг улсын тэмдэгтийн хураамж бүрэн төлсний дараа олгож байх

Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, байршлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативд үндэслэн сумын ИТХ-ын шийдвэрээр тогтоох

5. Тусгай зөвшөөрөл хүссэн худалдаа, үйлчилгээний цэгт тавих босго онооны хэмжээ, хязгаарыг мэргэжлийн байгууллагуудаас баталсан стандарт, шаардлага, дүгнэлт зэргийг харгалзан тогтоох

6. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тухай хүсэлтийг сумын ИТХ-аас тогтоосон цэгийн тоо, нормативд үндэслэн хүлээн авч, цэгийн тоог нормативаас хэтрүүлэхгүй байх

Сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, татварын улсын байцаагч нарт:

7. Улсын тэмдэгтийн хураамжийг нэр төрлөөр үндэслэлтэй төлөвлөж, улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу тооцож, төсөвт бүрэн төвлөрүүлж байх

8. Нотариатын бүртгэлийн дэвтрийг журмын дагуу хөтөлж, тайлан мэдээг гаргаж хэвших

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Б.ЧИМЭДЦЭРЭН
П.НОРПИЛ



Г ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас: 7032-2073

2018. 11. 07 № 28/548
танай _____ -ны № _____ -г

Г Хариу хүргүүлэх тухай Г

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар аймгийн Засаг даргаас "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд тусгай зөвшөөрөл олгох" чиг үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс хариуцан зохион байгуулдаг.

Аймгийн Засаг даргын 2017 оны а/638 дугаар захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, зөвлөлийн чиг үүрэг, хариуцан ажиллах чиглэлийг журамлан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 72 дугаар тогтоолоор "аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих" журмыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яамны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлэн хэрэгжүүлж, 2018 онд журмыг мөн шинэчилсэн.


Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар батлагдсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, норматив баталсан шийдвэр нь Хууль зүй, дотоод хэргийн яамны улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэн, хэрэгжүүлэх эрх олгогддог бөгөөд тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүний эрх зөрчсөн гэх үндэслэлээр бүртгэхээс татгалзаж, орон нутагт хэрэгжүүлэх, дагаж мөрдөх шаардлагагүй гэсэн чиглэл хүргүүлж байсан.

Иймээс аймгийн хэмжээнд дээрх асуудлыг зохицуулах, тусгай зөвшөөрлийн цэгийн тоо, нутаг дэвсгэрийн хамаарал, орон нутгийн төрийн байгууллага, иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хамтын шийдвэр гаргаж байх үүднээс тусгай зөвшөөрлийн хүсэлт, дүгнэлтийг гаргах эрх, чиг үүргүүдийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын дэргэд байгуулагдсан орон тооны бус ажлын хэсэгт олгож, журмын хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Танай байгууллагаас хийсэн хяналт, шалгалтын дүнг "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих" чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд танилцуулж, зөвлөмжийн мөрөөр цэгийн тоог хязгаарлах, тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд аттестатчилал зохион байгуулах, хяналтыг сайжруулах, сумдад ажиллаж байгаа орон тооны бус ажлын хэсгийг чадавхижуулах, иргэд, ААН, байгууллагыг чирэгдүүлэхгүй байх талаар арга зүйн зөвлөмж өгөх тодорхой ажлыг зохион байгуулах болно.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

А.ОТГОНЦЭЦЭГ



012200220

D:My Doc. A4 albanbichig /ZDTG/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/18.

Арвайхээр

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 19 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, мөн 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим заалтын 2016-2017 оны хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайлан /ӨВА-2018-01-ГА/-г баталсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, сумдын ИТХ, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн аймгийн Засаг дарга /Г.Ганболд/, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга /А.Отгонцэцэг/, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер /Д.Гансүх/-т даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Л.ЛАМААЧИН



450107

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим заалтын 2016, 2017 оны хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцагчийн нэр		Төлбөр зөрчлийн товч утга		Аудиторын нэр	Актны дугаар	Төлбөрийн дүн	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
	нэр	албан тушаал	Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр зөрчлийн товч утга					
1	А.Отгонцэцэг, Б.Анхбилэг	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, Аймагын ЗДТГ-ын ХЭХ-ийн мэргэжилтэн	Сотууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2016 оны а/423 дугаар захирамжаар шинээр авсан Арвайхээр сумын Өнөр хүнсний дэлгүүр, Өнөр кафе улсын тэмдэгтийн хураамж 900.0 мянган төгрөгийг дутуу төлсөн байна.	Б.Чимэдцэрэн, П.Норпил	ӨВА-2018-01-ГА-22	900.0			
2	А.Мөнхбат, М.Мөнхбаатар	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Баянгол сум нотариатын үйлчилгээний хураамжийн орлогыг 2016 онд 376.2 мянган төгрөг, 2017 онд 185.8 мянган төгрөг, нийт 562.0 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Б.Чимэдцэрэн, П.Норпил	ӨВА-2018-01-ГА-28	562.0			
	Д.Батарччулуун, С.Далаасүрэн	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Баруунбаян-Улаан сум нотариатын үйлчилгээний хураамжийн орлогыг 2016 онд 587.5 мянган төгрөг, 2017 онд 244.7 мянган төгрөг, нийт 832.2 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Б.Чимэдцэрэн, П.Норпил	ӨВА-2018-01-ГА-27	832.2			
	Ч.Чинзориг, Д.Тунгалар	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Богд сум нотариатын үйлчилгээний хураамжийн орлогыг 2016 онд 752.2 мянган төгрөг, 2017 онд 347.2 мянган төгрөг, нийт 1099.4 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Б.Чимэдцэрэн, П.Норпил	ӨВА-2018-01-ГА-26	1099.4			

(мянган төгрөгөөр)

	Б. Батбаяр, Д. Чулуунбадрах	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Төгрөг сум нотариатын үйлчилгээний хураамжийн 2017 оны орлого 138.3 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Б. Чимэдцэрэн, П. Ноприл	ӨВА- 2018-01- ГА-25	138.3			
	Р. Лхагвасүрэн, Д. Уранчимэг	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Хужирт сум нотариатын үйлчилгээний хураамжийн орлогыг 2016 онд 267.5 мянган төгрөг, 2017 онд 105.0 мянган төгрөг, нийт 372.5 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Б. Чимэдцэрэн, П. Ноприл	ӨВА- 2018-01- ГА-24	372.5			
	Б. Сугар, П. Сольботох	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Нарийнтээл сум нотариатын үйлчилгээний хураамжийн орлогыг 2016 онд 81.2 мянган төгрөг, 2017 онд 346.1 мянган төгрөг, нийт 427.3 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Б. Чимэдцэрэн, П. Ноприл	ӨВА- 2018-01- ГА-23	427.3			
	Нийт дүн						4331.7		0.0

НЭЛГТЭСЭН:

ХЯНАСАН:

/Б. ЧИМЭДЦЭРЭН/

/Д. ГАНСУХ/

